



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/439

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тулгар төрийн 2228, Их Монгол улс байгуулагдсаны 813, Ардын хувьсгалын 98 жилийн ойн баярыг тохиолдуулан Эх орон, ард түмнийхээ төлөө өргөсөн тангарагтаа үнэнч байж, албан үүргээ нэр төртэй гүйцэтгэн хамт олноо манлайлан олон жил үр бүтээлтэй ажиллаж буй нэр бүхий иргэдийг Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 210000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2.Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 210000 төгрөг / хоёр зуун арван мянган/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.


3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны
07 дүгээр сарын 09-ний өдрийн
А/439 дүгээр захирамжийн хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН "ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ"-ӨӨР
ШАГНАГДАХ ХҮМҮҮСИЙН НЭРС

№	Овог нэр	Эрхэлж буй ажил, албан тушаал	Олгох шагнал
1	Б.Уранчимэг	Гадаадын иргэн харъяатын Баруун бүс дэх газрын мэргэжилтэн	30000
2	Э.Сүхбаатар	Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн станцын дарга, ахлах ахлагч	30000
3	Д.Ариунбилэг	Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн Хүнсний албаны сав угаагч	30000
4	П.Тамир	Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн Хүнсний албаны тогооч	30000
5	Б.Отгонжаргал	Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн Холбооны дарга, ахмад	30000
6	Б.Бадмаараг	Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн Зенитийн салааны жолооч, телефончин	30000
7	Г.Даваасүрэн	Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн ээлжийн слесерь	30000
Дүн			210000

-оОо-